



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/Ч/16

Мөрөн сум

Гэрээ цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн 221 дүгээр зүйлийн 221.3, 222 дугаар зүйлийн 222.1.2, 225 дугаар зүйлийн 225.1, 225.2, 355 дугаар зүйлийн 355.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГ-ын 2024 оны гэрээ цуцлах тухай 02/98 албан тоот, мөн аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг биелүүлээгүй байдлыг үндэслэн “Сайрын харгана” ХХК-тай 2023 оны 10 дугаар сарын 10- ны өдөр хийсэн Хөвсгөл аймгийн Рашаант сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажил гүйцэтгэх 704,480,668 (Долоон зуун дөрвөн сая дөрвөн зуун наян мянга зургаан зуун жаран найман) төгрөгийн үнэ бүхий гэрээг цуцлахаар шийдвэрлэсүгэй.

2.Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн зардлаас Рашаант сумын сургуулийн засварын ажлын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ